

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.2 Төслийн зорилго:	2
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:.....	2
1.4 Төслийн хүчин чадал:	2
1.5 Уулын ажлын горим.....	2
1.6 Үйлдвэрлэлийн нөөц	3
1.7 Уурхайн ашиглалтын систем	3
1.6.1 Уурхайн ашиглалтын элементүүд	3
1.7 Уурхайн дэд бүтэц	4
1.7.1 Уурхайн барилга, байгууламж	4
1.8.3 Цахилгаан хангамж	5
1.8.4 Усан хангамж.....	5
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ.....	6
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил	6
2.2 Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл	6
2.4 Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын өндөршилт:.....	8
БҮЛЭГ 3. УУР АМЬСГАЛ	9
3.1 АГААРЫН ТЕМПЕРАТУР.....	9
3.2 ХУР ТУНАДАС.....	10
3.3 АГААРЫН ЧИЙГШИЛ, %.....	11
3.4 ЦАГ АГААР	11
БҮЛЭГ 4. АГААРЫН ЧАНАР.....	13
4.1 АГААР БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРҮҮД.....	13
4.2. АГААРЫН ЧАНАРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ	13
4.2.1 Хүхэрлэг хий (SO ₂)	13
4.2.2 Азотын давхар исэл (NO ₂).....	14
4.2.3 РМ 10 тоосонцор	14
4.2.4 РМ 2.5 тоосонцор	14
БҮЛЭГ 5. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
5.1 МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
7.1 Биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	28
БҮЛЭГ 13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	31
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	33

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр:

Улаанбаатар хот Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод элс” элсний ордыг ил уурхайн аргаар төсөл

1.2 Төслийн зорилго:

Улаанбаатар хотын Төмөр бетон заводын үндсэн түүхий эдийн нэг хэсэг болох элсээр хангах замаар барилгын материал үйлдвэрлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Аж ахуйн нэгжийн эрх: “Ай Эф Соонс” ХХК нь Монгол улсын 9011100037 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Орд ашиглах тусгай зөвшөөрөл:

- 2007 оны 01 сарын 29 өдөр АМГТГ-аас 77 га талбайг авсан.
- 2008 оны 03 сарын 04 өдөр талбайн хэмжээнээс 65.52 га талбайг хэсэгчлэн буцааж өгсөн.
- “Ай Эф Соонс” ХХК-д 2008 онд ГУУКГ-ын даргын шийдвэрээр шилжүүлэн олгосон байна.

Тусгай зөвшөөрлийн дугаар MV-001903. Тусгай зөвшөөрлийн талбай нь хойд талаараа Мон-Элс ХХК /MV-000883/, урд талаараа Сэрүүн сэлбэ ХХК /MV-013323/-тай хиллэдэг.

Төсөл хэрэгжүүлэгч	“Ай эф соонс” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011100037
Регистрийн дугаар	
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-017191.
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо энхтайвны өргөн чөлөө 13/3 Авзага трейп ХХК-ийн байр 804 тоот
Утас	99994774

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

1.4 Төслийн хүчин чадал:

Төслийн хүчин чадал 40.0 мян.м3 /жил бөгөөд төслийн үргэлжлэх хугацаа 5 жил байна.

Зуун модны элсний орд нь ил уурхайн аргаар, автотээвэртэй ашиглалтын системтэйгээр 2010 оноос хойш ашиглалтын үйл ажиллагааг явуулж байна. 2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны тайлангаар баталгаажсан бодитой В зэргээр 211.75 мян.м 3 элс үлдсэн байна.

1.5 Уулын ажлын горим


“Зуун модны элс” элсний ил уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 5 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ажилладаг. Уурхайн ажлын горимд жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлийн хоног, мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хоногуудыг тус тус оруулан тооцлоо.

Хүснэгт 1 Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Хоног
Календарь хоног	365
Хүйтний улирлын түр зогсох хоног	181
Цаг агаарын хүндрэл	5
Техникийн засвар үйлчилгээ	5
Баяр ёслолын хоног	7
Жилд ажиллах хоног	164
Хоногт ажиллах ээлжийн тоо	1
Ээлжийн үргэлжлэх хугацаа	8

1.6 Үйлдвэрлэлийн нөөц

“Зуун модны элс” элсний ордын нөөцийг бодитой В зэргээр 632.7 мян.м³, хайрга, элсний хольцын давхаргын нөөцийг С зэргээр 187.7 мян.м³ гэж тогтоон Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.



Зураг 1 Ил уурхайн дэвсгэр зураг

1.7 Уурхайн ашиглалтын систем

Зуун модны элсний орд нь ил уурхайн аргаар, автотээвэртэй ашиглалтын системтэйгээр 2010 оноос хойш ашиглалтын үйл ажиллагааг явуулж байна. 2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 2021 оны ашиглалтын үйл ажиллагааны тайлангаар баталгаажсан бодитой В зэргээр 211.75 мян.м³ элс үлдсэн байна.

1.6.1 Уурхайн ашиглалтын элементүүд

Доголын өндөр: Ордын элсний давхарга нь харьцангуй бага зузаантай, мөн хуулах хөрсний зузаан дунджаар 0.15 м, зарим хэсэгтээ хөрсний давхарга байхгүй тул ордыг олборлолтын 1 доголоор ашиглах ба доголын өндөр ордын геологийн тогтцоос

хамааран 3.5-8.5 м байна.

Доголын хажуугийн өнцөг: Доголын хажуугийн өнцгийг чулуулгийн тогтворжилтоос хамааруулан 40 градус байхаар сонгосон.

Уурхайн замын өргөн: Уурхайн замын өргөнийг тухайн замаар явах тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааруулан 10 м байхаар тооцсон

Хүснэгт 2 ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Ил уурхайн ажлын доголын өндөр	М	3.5-8.5
2	Доголын хажуугийн өнцөг	Градус	40
3	Траншейн замын өргөн	М	10
4	Траншейн дагуу налуу	Хувь	90

1.7 Уурхайн дэд бүтэц

1.7.1 Уурхайн барилга, байгууламж

“Зуун модны элс” ордын уурхайн барилга байгууламж, ашиглалтын үеийн үйл ажиллагаанд шаардагдах эрчим хүчний хангамж, засвар үйлчилгээ зэрэг дэд бүтцийн барилга байна.

Хүснэгт 3 Барилга байгууламж хийц бүтэц

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, ш
1	Ажилчдын байр	Сэндвич	1
2	Хоолны байр	Сэндвич	1
3	Халуун усны байр	Сэндвич	1
4	Бараа материалын агуулах	Сэндвич	1
7	Харуул хамгаалалтын байр	Сэндвич	1
	Дүн		5



Зураг 2 Ажилчдын амрах байр



Зураг 3 Сэлбэг материал, хувцас солих өрөө

1.8.3 Цахилгаан хангамж

2009 онд “Электросеть проект” ХХК-иар уурхайн цахилгаан хангамжийн техник - ажлын зургийг хийлгэж, техникийн нөхцөлийг УБЦТСүлжээ ХК баталсан байна. Цахилгаан угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар, зохих стандартын дагуу хийлгүүлж улсын комисст 2010 онд хүлээлгэн өгсөн.

Орд дээрх бууруулах дэд станцыг 300 м урттай 35кВ-ын агаарын шугамаар тэжээгддэг.

Уурхайн цахилгааны гол хэрэглэгч нь шигшигч, конвейер болон гүний усны насос, засварын цех, бусад жижиг хэрэглэгчид байна. Мөн элсний шигшүүр, засварын талбай, автомашины зогсоол, ажилчдын сууц болон бусад байгууламж, явган зорчигчдын талбай зэргийг харанхуй үед гэрэлтүүлэх гэрэлтүүлэг байна.

1.8.4 Усан хангамж

Налайхын Зуун модны элсний орд нь гидрогеологийн хувьд энгийн нөхцөлд оршдог. Элсний ордын орчимд гадаргын усан сүлжээ байхгүй, уурхайн усны хэрэгцээг гүний худгаар хангадаг. Гүний худгийг тусгай зөвшөөрлийн талбайд элсний чулуулгийн ул гарсан хэсгээс доош ус агуулагч давхарга хүртэл 30-40 м гүн өрөмдөж, уг худгаар үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээний усыг хангадаг.

- Эзэмшигч байгууллага: “Ай эф Соонс” ХХК
- Худаг гаргасан байгууллага: “Эрдэнэдрийлинг” ХХК
- Худгийн байршлын солбилцол: 107°18' 35" , 47°47' 33"
- Үнэмлэхүй өндөр: 1417м
- Цооногийн гүн: 40м
- Усны ундарга: 1.6 л/сек

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил

“Зуун модны элс” элсний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших ба Улаанбаатар хотоос 50 км, Налайх дүүргээс 18 км зайд байрлана.

Хүснэгт 4 MV-001903 тусгай зөвшөөрлийн солбицол

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	107° 29' 13.58"	47° 47' 34.76"
2	107° 28' 36.37"	47° 47' 25.16"
3	107° 28' 36.37"	47° 47' 34.76"




Зураг 4 Төслийн талбайн зураг

2.2 Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл

Физик газарзүй: Судалгааны талбай нийтдээ Хэнтийн нурууны баруун урд үзүүрт хамаарах бөгөөд Туул гол болон түүний цутгалуудын хөндийнүүдээс бүрдэнэ. Эдгээр нь дунд зэргийн өндөртэй уулсаар хүрээлэгддэг. Талбайн баруун талд 2,268 м үнэмлэхүй өндөртэй Богд уул, 1,833 м үнэмлэхүй өндөртэй Баянзүрх уулууд оршдог. Талбайн хойд захаар эгц дээш тогтсон хадан цохио маягийн Горхийн (2,120 м) уулс Туулын дагуу сунаж тогтсон. Уулаас эх авсан булгууд нийлж Горхийн голыг бүрдүүлэн Туул голд Налайхын хотгор орчимд цутгана.


Газарзүй: Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулсын баруун урд хэсэгт уртаараа 20км, өргөнөөрөө 10 км хүртэл үргэлжлэх ба Налайхын хотгорт хамаарагдана. Уул зүйн хэлбэршлийн хувьд далайн түвшнээс дээш 1400-1550м өргөгдсөн хотгор гүдгэр хэв шинжтэй, намхан бэсрэг уулсын толгодорхог гадаргуутай юм.



Зураг 5 Байгалийн бүс бүслүүр

2.3 Төслийн талбайн газрын гадаргын налуужилт:

Газрын гадаргын налуу нь суурьшлын бүс газрын барилга, байгууламж барьж байгуулахад ихээхэн нөлөөтэй болохыг зураг төсөл боловсруулах, барилга байгууламжбарих талбайн бэлтгэл, газар шорооны ажилтай шууд холбож үздэг. Газрын гадаргынналуу ихсэх тутам газар шорооны ажлын хэмжээ мөн төдий чинээ нэмэгддэгтэйхолбоотой.Иймд газрын гадаргын налуугийн олон төрөл байдал нь хот төлөвлөлтийн үүднээсэзлэхүүн, орон зайн төлөвлөлтөд өвөрмөц үүрэг гүйцэтгэх нь маргаангүй бөгөөд хот,суурингийн янз бүрийн үүрэг зориулалтын бүсүүдийг гадаргын налуугийн хүчин зүйл,тухайн суурингийн онцлог байдалтай уялдуулан төлөвлөж барьж байгуулах нь зүйтэй юм.




Зураг 6 Газрын гадаргын налуужилт

2.4 Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын өндөршилт:

Хот, суурингийн байрлаж буй газрын өндөржилт ихсэх тутам агаарынхүчилтөрөгчийн агуулга болон температур буурч, өдөр шөнийн температурын зөрүү огцомөсч, салхины хүч ширүүсэн, агаарын хуурайшил нэмэгдэн, цаг уурын бусадөөрчлөлтүүдээс шалтгаалж, оршин суугчдын ая тухтай байдал алдагдан, эрүүл мэндэднөлөөлөхөөс гадна барилга байгууламжийн ашиглалтад сөрөг үр дүн үзүүлдэг байна.Эмнэлэг-биологийн шаардлагаас үндэслэн, хот байгуулалтын хувьд далайнтүвшнээс дээш 1500 м хүртэл өндөржилттэй бол тохиромжтой, 1500-2500м хүртэл хязгаарлагдмал тохиромжтой, 2500 м-ээс дээш тохиромж муутай нөхцөлд үнэлэгдэж байна.

БҮЛЭГ 3. УУР АМЬСГАЛ

Улаанбаатар хот нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нь тэгш химийн хуваарилалттай, чийглэг зэврүүн зун, хахир өвөлтэй уур амьсгалын мужид багтах бөгөөд уур амьсгалын нөхцөлийн хувьд чийгийн хангамж 1- ээс их, нэмэх температурын нийлбэр буюу дулаан хангамж нь 15000С-ээс их нутаг болно.



Зураг 7 Уур амьсгал

Хүснэгтэд үзүүлснээр агаарын температур, хур тунадасны дундаж хэмжээ 7 дугаар сард 17.4°C 75.5мм их, 1-р сард -23.0°C 1.0 мм бага үзүүлэлттэй байна

3.1 Агаарын температур

Жилийн дундаж агаарын температур төв хэсэгтээ -4.0°C- ээс хүйтэн байх боловч газрын гадаргаас ихээхэн шалтгаалж өөр байна.

Хүснэгт 5 Сарын дундаж агаарын температурын үзүүлэлт

Статистик үзүүлэлт	1	2	3	4	5	6	7	8
Дундаж	-28.8	-30.9	-14.6	3.2	15.3	19.6	19.3	17




График 1 Агаарын температур

3.2 Хур тунадас

Хилд унах хур тунадасны нийлбэр олон жилийн дунджаар 350 орчим мм байхаас, 95-97 хувь нь дулааны улиралд унах ба олон жилийн нийлбэрийн дундаж нь 100-120мм

Статистик үзүүлэлт	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
Нийлбэр	2.1	3	6.3	11.7	27.7	63.7	94	85.1	33.4	10.4	5.4	2.8	345.7



График 2 Хур тунадасны сарын дундаж үзүүлэлт

2021 оны байдлаар Тэрэлж өртөө орчим 345,7 мм хур тунадас унасан байна. үүнээс харахад төслийн талбай орчим хур тунадас харьцангуй сайн ордог бүс нутагт хамаарна. 2021 оны байдлаар нийт орсон хур тунадасны 87,9% нь 5-9-р сарын хооронд бороо хэлбэрээр

орсон байна. төслийн талбай орчим 2021 оны байдлаар хамгийн их хур тунадас орсон сар нь 7-р сар 94 мм бол хамгийн бага хур тунадас унасан сар нь 1-р сард 2,1 мм байна.

3.3 Агаарын чийгшил, %

Харьцангуй чийгшил нь тухайн агаар чийгээр хангахад шаардагдах чийгийн хэмжээний хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлнэ. Энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын чийглэг буюу хуурай болохын шинж төлөвийг илэрхийлэх маш чухал үзүүлэлт бөгөөд түүнийг уур амьсгалын судалгаанд өргөн хэрэглэдэг. Харьцангуй чийгшил нь 7,12,1 саруудад их байдаг нь дулааны улирлын хур тунадас их ордогтой, өвөл манай оронд хүйтрэхэд агаарын чийг агуулах чадвар багасдагаар тайлбарлагдана. Жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр 15-20 өдөр тохиолдож байхад 30-40 өдөр нь 80%-иас дээш чийгтэй байдаг. Зарим жилд өдрийн харьцангуй чийгшил 10%-иас доош орох тохиолдол гарч байсан байна.



График №. 1 Салхины хурд

3.4 Цаг агаар

Төслийн талбайн орчим сүүлийн 72 цагийн цаг агаарын мэдээгээр 9-р сарын 13ны 14цаг орчимын үед хамгийн өндөр халсан төлөв ажиглагдаж байна. Харин салхины хурд 14 цаг орчмын үед 5м/с хурдтай байна.

Нийслэл – Налайх дүүрэг (Станц: Тэрэлж)



График 3 Цаг агаар

БҮЛЭГ 4, АГААРЫН ЧАНАР

4.1 Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Төслийн талбай орчим нь хур бороотой зунтай, хүйтэн өвөлтэй мужид багтдаг бөгөөд үе үе эрс хүйтрэх, ган зуд болох зэргээр цаг агаарын эрс тэс байдал, салхины зонхилох чиглэлийн давтагдал, цасан ба шороон шуурга, хүчтэй салхи, салхины ачаалал нь байгалийн гаралтай тоос шорооны бохирдол тархах гол хүчин зүйл болдог. Төсөл хэрэгжих талбай орчимд агаарын бохирдуулагчдын нэг үзүүлэлт болох тоосны гол эх үүсвэр нь байгалийн тоос шороо, машины хөдөлгөөнөөс ялгарах, гэр хорооллын зуух яндангаас гарах хорт утаа зэрэг юм.

4.2. Агаарын чанарын ерөнхий төлөв байдал

4.2.1 Хүхэрлэг хий (SO_2)

Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж нь 2023 оны 07-р сарын 31-ний өдрөөс 08-р сарын 06-ний өдрийн байдлаар хүхэрлэг хий (SO_2) тоосонцор нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. /Улаанбаатар хотын нээгдсэн дүнг ашиглав/




График №. 1 Хүхэрлэг хийн хэмжээ

4.2.2 Азотын давхар исэл (NO₂)

Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж нь 2023 оны 07-р сарын 31-ний өдрөөс 08-р сарын 06-ний байдлаар Азотын давхар исэл (NO₂) тоосонцор нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. /Улаанбаатар хотын нэгдсэн дүнг ашиглав/




График №. 2 Азотын давхар исэлийн хэмжээ

4.2.3 PM 10 тоосонцор

Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж нь 2023 оны 07-р сарын 31-ний өдрөөс 08-р сарын 06-ний өдрийн байдлаар PM 10 тоосонцор нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. /Улаанбаатар хотын нэгдсэн дүнг ашиглав/




График №. 3 PM 10 тоосонцорын хэмжээ

4.2.4 PM 2.5 тоосонцор

Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламж нь 2023 оны 07-р сарын 31-ний өдрөөс 08-р сарын 06-ний өдрийн байдлаар PM 2.5 тоосонцор нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. /Улаанбаатар хотын нэгдсэн дүнг ашиглав/




График №. 4 PM 2.5 тоосонцрын хэмжээ

Төсөл хэрэгжих цахилгаан станц орчим 2023 оны 07-р сарын 31-ний өдрөөс 08-р сарын 06-ний өдрийн нарийвчилсан хэмжилтийн үр дүнгээр 07-р сарын 31 болон 08-р сарын 01-ны өдрүүдэд бага бохирдолтой. Харин 08-р сарын 02, 03, 06-ны өдрүүдэд цэвэр, 08-р сарын 04, 05-ны өдөр хэвийн түвшинд байсан байна.

ДҮГНЭЛТ

Агаарын чанарын үзүүлэлт тус бүрийн хэмжилтийг МУ-ын АГААРЫН ЧАНАР. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА. MNS4585:2016 стандарттай харьцуулж агаарын чанарыг тодорхойлсон ба дээрхи үзүүлэлтийг стандарттай харьцуулсан болон индексээр тооцсон дүнгээс үзвэл, хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу цэвэр байхын зэрэгцээ хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөгүй байна. Судалгаагаар тус төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг талхлагдаагүй, 20-30 хувийг ойн төгөл эзлэж байсан тул агаарын бохирдол бага байсан.

БҮЛЭГ 5. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;

2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо.

Тус төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, мөн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны

менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны менежментийн төлөвлөгөөний ажилд зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	1.2
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	0.5
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	0.7
8	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	0.6
9	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
10	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	-
	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	4.0

БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
Агаарын чанар								
Тоосжилт болон бохирдуул агч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер, овоолго, зам, талбай, шигшүүрийн талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох; Уурхайн дотоод замаас тоос шороо дэгдэхээс хамгаалах, усалгаа хийх;	Үйл ажиллагааны турш	-	0.3	-	0.3	2024	БОС-ын 1995 оны 154 тоот тушаал Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 : 2007
	Элсийг ачих, буулгах цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах; цэвэршүүлэх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	2024	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	2024	

	Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх;	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	2024	
	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт болон хор саармагжуулах бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах; Мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах;	Ажиллах нийт хугацаанд Бүх ажилчдад	-	-	-	Ү.А-ны зардлаар	2024	
Хөрсөн бүрхэвч								
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын байгалын унаган төрх өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолгыг 2 жилээс дээш хугацаанд хадгалах тохиолдолд олон насаар ургамалжуулах;	Үйл ажиллагааны турш	-	0.1	-	0.1	Жолооч операторуудад сургалт явуулсан.сanh.	MNS 5915:2008
	Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, замыг тэмдэгжүүлж, олон салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулга самбар хийж байгуулах, ухуулга сурталчилгаа хийх	Үйл ажиллагааны турш	-	-	-	Ү.А-ны зардлаар		
	ШТМ-ыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	-	-	-	Ү.А-ны зардлаар		

	ШТМ-ын агуулах болон засварын төвийн газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх, засварлан сэргээх	Үйл ажиллагааны турш	-	0.5	-	0.5		
	Бохирдсон хөрсийг цэвэрлэх, ариутгах арга хэмжээ авч байх	Үйл ажиллагааны турш	-	0.2	-	0.2		
Усны нөөц, усны чанарт								
Газар доорхи усны түвшин ашиглалтын улмаас буурах	Үйлдвэрлэлийн болон ахуйн ус хэрэглээний хэмжээг нарийвчилан тооцож, усыг дахин хэрэглэх, хэмнэлттэй зарцуулах техник технологи судлах, ашиглах; Мөн ашиглагдсан саарал усаар зам талбай болон ногоон байгууламж зэргийг услах зэрэг ажлыг судлан зохион байгуулах	Төслийн явцад	-		-	Ү.а-ны зардлаар	+	“Усны тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 33 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу усыг хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлэх Усны тухай хууль, БОНХАЖСайд, БХБСайдын хамтарсан 2015-06-05-ны А230/127 тоот тушаал
	Унд ахуйн эх үүсвэр ашиглагдаж буй худагт ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож зохих хууль журамд заасан дэглэмийг мөрдөх	Галын аюулгүй ажиллагааны хүрээнд	-		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	+	“Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам Усны тухай хууль
	Ус ашиглалтын гэрээг сав газартай хийж, ус ашиглалтын төлбөрийг тусгай дансанд оруулах	Ажилчдын байрны хүрээнд	-		-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Сард 1 удаа	
Ахуйн хаягдал, шатах,	Хотхоны ахуйн бохир усыг цуглуулах цооног байгуулах, халдваргүйжүүлэх	Төсөл хэрэгжих нийт хугацаанд	-	-	-	-	2024	“Хог хаягдлын тухай хууль” 10.2-р зүйл

Тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх, дахин боловсруулах үйлдвэр болон компаниудад нийлүүлэх гэрээ хийх;	Төсөл хэрэгжих нийт хугацаанд	-	-	-	-	2024	
	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг түр цуглуулах цэг байгуулах, тушаах арга хэмжээг зохион байгуулах;	Ажиллах нийт хугацаанд	-	0.1	-	0.1	2024	БОАЖСайдын 2017 оны 12 сарын 25-ны өдрийн А-368-р тушаал, “Хог хаягдлын тухай хууль”, 10.2.3, 10.2.4-р зүйл
Амьтны аймаг, ургамлан нөмрөг								
Төслийн нөлөөгөөр амьтны тоо толгой цөөрөх ургамлан нөмрөг талхлагдал д орох зүйлийн бүрдэл өөрчлөгдөх	АМТЗ-ын талбайн хэмжээнд болон нөлөөллийн бүсэд ургамлын бичиглэл тогтмол хийж, зүйлийн бүрдэл, биомасс, өөрчлөгдөх зэрэгт хяналт тавьж ажиллах	АМТЗ-ийн талбай болон нөлөөллийн бүсэд	-	-	-	Ү.а-ны зардлаа р	2024	
	Зэрлэг ан амьтны хамгаалах, идэш тэжээлийн фондонд жил бүр тодорхой хэмжээгээр мөнгөн тусламж үзүүлэх	Төсөл хэрэгжиж буй сум орон нутгийн хэмжээнд	-	-	-	2024	2024	
Нийт	1.2 сая.төг							

БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1 Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа өө давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Уурхайн бэлтгэл ажлын үед хийх нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолго хийх		ҮАЗ-д	2024	MNS 5916-2008
		Шимт хөрсний овоолгыг хамгаалах		ҮАЗ-д	2024	
2	Уурхайн хаалтын нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт хийх	Дотоод зохион байгуулалтаар	7.0	2024	MNS 5917-2008
		Биологийн нөхөн сэргээлт хийх			2024	MNS 5918-2008
Нийт				Мян.төг		

БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1 Биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2024		
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ							
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд сонгон авсан газар нутаг болох Богд Хан уулын ДЦГ-ын захиргаатай хамтран ажиллах ба шаардлагатай мөнгөн тусламжийг үзүүлэх	Богд Хан уулын ДЦГ	-	2024	Дотоод зохион байгуулалтаар		
	Зэрлэг ан амьтны хамгаалах, идэш тэжээлийн фондонд жил бүр тодорхой хэмжээгээр мөнгөн тусламж үзүүлэх	Богд Хан уулын ДЦГ	-	2024	Дотоод зохион байгуулалтаар		
Нийт дүн, мян.төг			мян.төг				

БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан байдаг.

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

БҮЛЭГ 11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 3 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2024	

	талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх					
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт		0.2	0.5	2024
	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх					2024
	Галын сараа байгуулах					
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх					
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах,					
	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах			0.3		
Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах				-	2024 онд
Нийт зардал (мян.төг)				0.5		

БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
Хог хаягдлын цэгийг MNS 5906:2015 стандартад нийцүүлэн ашиглалтанд оруулах	Хатуу хог хаягдлын түр цэгийг стандартын дагуу хийх	Хог хаягдлын цэгт	-	-	-	Ү.а зардлаар	2024	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдалын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах.	Төслийн талбайн бүх барилга байгууламж уудад	-	0.5	-	0.5	2024	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд	-	-	-	ОХШХ-т тусгасан аар	2024	MNS 3936:1986 Ундны ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Стандарт нийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд	-	-	-		2024	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018

Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хаягдлын хүрээнд	-	0.5	-	0.5	2024	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдолоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
Нийт		1.0 сая.төг						

БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2024 он	Давт амжин тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар								
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	1.Төслийн үйл ажиллагааны үед агаарын чанарын дээжлэлт хийх 2.Төслийн үйл ажиллагааны үед ашиглах тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдолын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх.	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Улирал тутамд	Жилд 2 удаа	40.0	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 1 удаа* 1 жил НИЙТ 40.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотокolorиметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Хүдрийг буулгах овоолох цэгт	Улирал тутамд	Жилд 2 удаа	40.0	Шинжилгээний зардал: 1 удаагийнх 40.0 х 1 цэг х жилд 1 удаа *1 жил НИЙТ 40.0	

3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам, уурхайн ойр орчимд 2 цэгт	Улирал тутамд	Жилд 2 удаа	30.0	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 2 удаа* 1 жил НИЙТ 30.0
Хөрсний бохирдол							
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох	Хагас жил тутамд	Жилд 1 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /30.0/ НИЙТ 30.0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж- 15.0 төг, MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний

	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	Дээрх цэгт 2	2024 он	Жилд 1 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 1 жил х 15,0 Нийт 30 хүнд металлын шинжилгээ 1 дээж-15.0 төг/	болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
Усны хяналт шинжилгээ									
1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2024 он	Жилд 2 удаа	20.0	20.0*2 удаа х 1жил НИЙТ 40.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт	
орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2024 оны зардлын дүн								0.7	

БҮЛЭГ 14. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт №. 4 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2024 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Далд уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		2024 он
2	Байгаль орчны аудит хилгэх	2 жилд тутамд 1 удаа	Дотоод зохион байгуулалтаар		2024
3	Байгаль орчныг хамгаалах, осол аваарь , гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт, судалгааний ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	уурхайн хүрээнд	Осол эрсдэлийн менежментийн зардалд		2024он
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Аж ахуй нэгжийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 12 сард
5	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Үйл ажиллагааны хүрээнд	Удирдлагын түвшинд		2024 он
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	уурхайн хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр		2024 он
7	Бүх ажиллагсадыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарт хамруулж байх	уурхайн хүрээнд	-	2024 он	2024 он
8	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	уурхайн хүрээнд	Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх		3-р улирал

9	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
10	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
11	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	уурхайн хүрээнд	0.05	0.1	Жилд 2 удаа
12	Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах,	0.5		0.5	Жил бүр
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				0.6 мян.төг	

**БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД
ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Хүснэгт №. 5 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Нийслэлийн Налайх дүүргийн ажлын хэсэгт танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2024.11.01-нд хүргүүлэх	-	“Ай эф соонс” ХХК-ын байгаль орчны мэргэжилтэн	
Нийт				МЯН.ТӨГ		